Татварын ерөнхий газрын даргын
2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн
А/38 дугаар тушаалын 79 дүгээр хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- [√] Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- [ ] Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

| | |
|---|---|
| Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: | |
| Дагаж мөрдөх огноо: | |
| Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: | |

| | |
|---|---|
| Байгууллагын нэр: | Нэгжийн нэр: |
| ................аймгийн татварын хэлтэс | Бичил татвар төлөгчтэй харилцах тасаг |
| Албан тушаалын нэр: | Албан тушаалын ангилал, зэрэглэл: |
| Бичил татвар төлөгчтэй харилцах тасгийн дарга | Дэс түшмэл, ТЗ-7 |
| Ажлын цаг: | Ажлын байрны албан ёсны байршил: |
| Ажлын өдрийн 8 цаг | ...................................................................................... |
| Хөдөлмөрийн нөхцөл: | Онцгой нөхцөл: |
| Хэвийн | Хамаарахгүй |

## II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Аймгийн хэмжээнд татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих, төсвийн татварын орлогыг бүрдүүлэх, татвар төлөгчийг мэдээллээр хanган зөвлөгөө өгөх чиг үүргийн хүрээнд нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.

Төрийн албаны зөвлөлийн
2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн
43 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

[√] Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

[ ] Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

| | |
|---|---|
| Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: | |
| Дагаж мөрдөх огноо: | |
| Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: | |

| Байгууллагын нэр: | Нэгжийн нэр: |
|---|---|
| ................аймгийн татварын хэлтэс | Бичил татвар төлөгчтэй харилцах тасаг |
| **Албан тушаалын нэр:** | **Албан тушаалын ангилал, зэрэглэл:** |
| Бичил татвар төлөгчтэй харилцах тасгийн дарга | Дэс түшмэл, ТЗ-7 |
| **Ажлын цаг:** | **Ажлын байрны албан ёсны байршил:** |
| Ажлын өдрийн 8 цаг | ................................................................................ |
| **Хөдөлмөрийн нөхцөл:** | **Онцгой нөхцөл:** |
| Хэвийн | Хамаарахгүй |

## II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Аймгийн хэмжээнд татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих, төсвийн татварын орлогыг бүрдүүлэх, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх чиг үүргийн хүрээнд нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.

| Албан тушаалын зорилт:<br>1.Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, татварын бүртгэл, цахим татварын систем, татвар төлөгчдөд татварын үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих;<br>2.Төсвийн татварын орлогыг бүрдүүлэх, татварын өр хураах үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих;<br>3.Татварын орлогын бүртгэл, буцаан олголтын үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих;<br>4.Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлд нь хяналт тавих. | | | |
|---|---|---|---|
| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр<br>Туслах - Т,<br>Хариуцан гүйцэтгэх - Г<br>Хянах – Х<br>Шийдвэрлэх – Ш |
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1.Харьяалах татвар төлөгчийг бүртгэх, хувийн хэрэг хөтлөх, нэмэлт өөрчлөлт оруулах, татвар төлөгчийн гэрчилгээг цахим хэлбэрээр олгох, татвар төлөгчийг шилжүүлэх, эрэн сурвалжлах, бүртгэлээс хасах үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих; | Татвар төлөгчдөд татварын хуулийг сурталчлан таниулж хөнгөн шуурхай, чанартай үйлчилгээ үзүүлсэн байна. | Х |
| | 2.Татвар төлөгчид цахим гарын үсэг, нэвтрэх эрх, нууц үгийг олгох; | | Г, Х |
| | 3.Татварын хууль тогтоомжийг сурталчлах, татвар төлөгчийн ангилал /сегмент/-д тохирсон сургалт, удирдамжит арга хэмжээг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх ажиллагаанд хяналт тавих; | Татвар төлөгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байна. | Г, Х |
| | 4.Татварын тайлан хүлээн авах, тайлангийн боловсруулалт хийх, залруулсан тайланг хүлээн авах, зөрчилтэй тайланг залруулаагүй тохиолдолд холбогдох нэгжид шилжүүлэх, тайлангийн ирц хангуулах, хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, хяналт тавих; | Зөрчилтэй тайланг холбогдох нэгжид шилжүүлсэн байна. | Г, Х |

| | | | |
|---|---|---|---|
| | 5.Албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх үйл ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулах, хяналт тавих; | Албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. | Х |
| | 6.Татвар төлөгчтэй холбоотой хөндлөнгийн мэдээллийг холбогдох эх үүсвэрээс цуглуулах, ашиглах, судалгаа хийх үйл ажиллагааг хэрэгжүүлэх; | Хөндлөнгийн мэдээллийг цуглуулан үйл ажиллагаанд ашигласан байна | Г, Х |
| | 7 Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, автотээврийн хэрэгслийн агаарын бохирдлын болон авто зам ашигласны төлбөрийг хураах ажлыг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд орон нутгийн төрийн захиргааны болон хууль хяналтын байгууллагатай хамтран зохион байгуулах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих; | Төсвийн орлогын төлөвлөгөө биелүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна | Г, Х |
| | 8.Нутаг дэвсгэрийн хэмжээнд Татварын ерөнхий хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, өргөдөл гомдлыг шийдвэрлэлтэд хяналт тавих; | Өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд барагдуулах, хуулийн хэрэгжилтийг хангуулсан байна | Г, Х |
| | 9.Татварын буцаан олголт, урамшууллыг холбогдох нэгжтэй хамтран зохион байгуулах, хянах; | Холбогдох нэгжтэй хамтран зохион байгуулсан байна | Г, Х |
| | 10.Эрсдэл бүхий татвар төлөгчийг татварын төрлөөр хэсэгчилсэн, хялбаршуулсан хяналт шалгалтад хамруулах ажлыг татварын хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгжтэй хамтран цахимаар хийх, хэрэгжилтэд хяналт тавих;<br>*(Энэ хэсэгт ТАЗ-ийн 2023 оны 150 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан.)* | Хууль тогтоомжид нийцсэн байна | Х |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1.Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөгөөний төсөл боловсруулах, нэгтгэх, холбогдох нэгжид хүргүүлэх; | Төсвийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж үнэн зөв байдлыг хангасан байна. | Г,Х |
| | 2.Төсвийн татварын орлогын төлөвлөгөөг сар бүр нэр төрлөөр жигд хангаж биелүүлэх; | Улс, орон нутгийн төсвийн татварын орлогын төлөвлөгөөг жигд хангаж биелүүлсэн байна. | Г, Х |
| | 3.Татварын өр хураах үйл ажиллагааны чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, татвар төлөх хугацааны хөнгөлөлт үзүүлэх, өртэй татвар төлөгчийн хөрөнгийн байдлыг тогтоох, хөрөнгө битүүмжлэх, хураах, хадгалах, эд хөрөнгийн үнэлгээг тогтоолгох, эрх хязгаарлах болон түдгэлзүүлэх арга хэмжээг зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих, удирдлагыг мэдээллээр | Татвар төлөгчийн татвар төлөх түвшин, татварт хамрагдалт нэмэгдэх, татварын өрийн барагдуулалт тогтоосон шалгуур үзүүлэлтийг хангасан байна | Г, Х |

МОНГОЛ УЛС ЗӨВШӨӨРӨВ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | | | |
|---|---|---|---|
| | хангах; | | |
| | 4.Битүүмжилсэн хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлэх (дуудлага худалдаа), мөнгөн хэлбэрт шилжүүлсэн орлогыг хуваарилах үйл ажиллагааг холбогдох нэгжтэй хамтран зохион байгуулах, | Холбогдох нэгжтэй хамтран ажиллаж татварын өр барагдсан байна | Г, Х |
| | 5.Татварын өр хураах үйл ажиллагааг татвар төлөгчийн ангилал (сегмент), татварын хууль тогтоомж мөрдөлтийн зан хандлагад тохирсон нийтлэг ажиллагаар хэрэгжүүлэх; | Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангасан байна | Г, Х |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1.Аймгийн төсвийн төрийн санд байрших татварын орлогын дансны гүйлгээний бүртгэлд хяналт тавих; | Орлогын бүртгэлийн хяналт хэрэгжсэн байна. | Г, Х |
| | 2.Аймгийн төсвийн татварын орлогын гүйцэтгэлийг төрийн сангийн нэгжтэй сар бүр тулган баталгаажуулах үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлэх, аймгийн төсвийн татварын орлогын гүйцэтгэлийн мэдээллээр удирдлагыг хангах; | Аймгийн төсвийн татварын орлогын гүйцэтгэл баталгаажсан байна. | Г,Х |
| | 3.Аймгийн төсвийн татварын орлогын зарлагын хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, залруулгыг холбогдох мэдээллийн санд бүртгэх үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлэх, удирдлага арга зүйгээр хангах; | Хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | Х |
| | 4.Татвар төлөгчийн илүү төлсөн татварын буцаан олгох данс хөтлөх, дансны үлдэгдлийг баталгаажуулах үйл ажиллалаанд хяналт тавих; | Хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | Х |
| | 5.Татварын хууль тогтоомжийн дагуу татвар төлөгчийн, суутган тооцооллын бүртгэлийн хяналтыг хэрэгжүүлэх; | Хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | Х |
| 4 дүгээр зорилтын хүрээнд | 1.Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, баталгаажуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг тайлагнах; | Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, ажил үйлчилгээ үр дүнтэй хэрэгжиж, үнэн зөв тайлагнасан байна. | Г, Х, Ш |

| | | | |
|---|---|---|---|
| | 2.Нэгжийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллах; | Удирдлагаар ханган ажилласан байна. | Г, Х |
| | 3.Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг тухай бүр гаргаж өгөх, тайлагнах; | Мэдэгдэлийг тухай бүр гаргаж, тайлагнасан байна. | Г |
| | 4.Нэгжийн чиг үүрэгтэй холбоотой мэдээ, тайлан, судалгаа гаргах, танилцуулах; | Мэдээ, тайлан, судалгаа үнэн зөв, хугацаандаа гарсан байна. | Г |
| | 5.Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэж, үр дүнг мэдээлэх; | Үүрэг даалгаврыг хугацаанд гүйцэтгэж, эргэн тайлагнасан байна. | Г |
| | 6.Хариуцсан чиг үүргийн дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллаас ирүүлсэн өргөдөл, гомдол, албан бичгийг шийдвэрлэх, албан хэрэг хөтлөх, архивын нэгж бүрдүүлэх; | Хууль, тогтоомжид нийцсэн байна. | Г |
| | 7.Хууль, тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх. | Үүргээ зохих ёсоор хэрэгжүүлсэн байна. | Г |

| **III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА** | | |
|---|---|---|
| Боловсрол | Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй. | |
| Мэргэжил | - санхүү, банк (041201)<br>- эдийн засаг (0311)<br>- нягтлан бодох бүртгэл, татвар (0411)<br>- Менежмент ба удирдахуй (041301-041302).<br>*(Энэ хэсэгт Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 159 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан.)* | |
| Мэргэшил | Төрийн албанд мэргэшүүлэх зохих багц сургалтад хамрагдаж төгссөн байх. | |
| Туршлага | Туслах түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан байх. | |
| | Удирдан зохион байгуулах | - хариуцсан ажлаа төлөвлөх, зохион байгуулах;<br>- удирдлагадаа байгаа албан хаагчдын ажил үүргийг оновчтой хуваарилах, удирдах чадвартай;<br>- албан хаагчдын ажлын гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавьж, зохих заавар чиглэл өгөх;<br>- бусад. |
| | Дүн шинжилгээ хийх | - албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулж, дүгнэх;<br>- шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаварыг дүгнэх;<br>- татвар төлөгчийн ангилалын асуудлаар тоон мэдээлэл, баримт нотолгоонд тулгуурлан дүн шинжилгээ хийх; |

| | | |
|---|---|---|
| Ур чадвар | | - харьялах татварын төлөгчийн ангилал, татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр судалгааны үр дүн, шийдлийн хувилбаруудын үр дагаврыг харьцуулан үнэлэх;<br>- бусад. |
| | Асуудал шийдвэрлэх | - албан үүргийнхээ дагуу хариуцах ажил үүргийг хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх;<br>- татвар төлөгчдөд үйлчилгээ үзүүлэхэд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарын эерэг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах;<br>- аливаа харилцааг хэрэгжүүлэх арга замыг хууль тогтоомжид тусгах санал боловсруулах;<br>- гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах;<br>- бусад. |
| | Манлайлах | - Монгол Улсын хууль, тогтоомжийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдах;<br>- татвар төлөгчдөд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэх;<br>- төрийн албан хаагчийн болон татварын улсын байцаагчийн ёс зүйн дүрэм, үйлчилгээний стандартыг чанд сахин бусдыг манлайлан үзүүлэх;<br>- авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;<br>- хариуцсан нэгжийн үйл ажиллагаанд шинэлэг санаа үйлчилгээг нэвтрүүлэх, чиглүүлэх, албан хаагчдын шинэ санаачилга, бүтээлч хандлагыг дэмжих;<br>- татварын албаны үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг бусдад итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх;<br>- бусад. |
| | Бусад | - ажил гүйцэтгэх, хэрэгжүүлэх;<br>- албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах;<br>- компьютерийн хэрэглээний програмыг эзэмшиж, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэн ажиллах;<br>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах;<br>- багаар ажиллах, багийн амжилтыг үнэлэх, дэмжих;<br>- бусадтай нээлттэй, үнэнч шударга, чин сэтгэлээсээ харьцах;<br>- шаардлагатай бол тухайн албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн байх. |

**IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ**

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Аймгийн татварын хэлтсийн дарга.

| | |
|---|---|
| Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:<br>Татварын улсын байцаагч | Бусад харилцах субъект:<br>- Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хэлтэс, орон нутгийн харъяа газар, хэлтэс, хууль сахиулах |

| | |
|---|---|
| Татвар хураагч<br>Нийт....... | байгууллага;<br>- Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн ажилтан;<br>- Иргэн, аж ахуйн нэгж байгууллага. |
| **V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ** | |
| Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан: | Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр: |
| Албан тушаал:<br>ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА<br><br>.................................................. Л.НЭРГҮЙ<br>(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)<br>2020 оны 02 дугаар сарын 12-ны өдөр | Байгууллагын нэр:<br>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ<br>Шийдвэрийн огноо: 20 02 12<br>Дугаар: 43 |
| **Албан тушаалын тодорхойлолтыг баталсан** | |
| Байгууллагын нэр:<br>ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР<br>Шийдвэрийн огноо: 2020.02.17<br>Дугаар: А/38<br>(тамга/тэмдэг)<br>ДАРГА ................................ Б.ЗАЯАБАЛ<br>(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)<br>2020 оны 02 дугаар сарын 17-ны өдөр | |